



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/002/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: Saranchimegtst@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
5.2 Төлбөрийн акт	8
5.3 Албан шаардлага.....	8
5.1 Зөвлөмж.....	9
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХАА	Хөдөө аж ахуй
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БНСБС	Байгалийн нөхөн сэргээх барьцаа сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.03.24 № 01/248
танай -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГА М.АНХБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Дэлгэрхаан сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан татварын орлогыг 4 нэр төрөлд 92,729.6 мянган төгрөгөөр тасалсан, Хоршоо хөгжүүлэх сангийн нийт үлдэгдлийн 89,3 хувь буюу 294,136.1 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл хугацаа хэтэрсэн зэрэг зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 23 дугаар зүйлийн 23.1-д "Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ", 23.8-д "Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасан заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Дуутын хадны бичээсний 400 жилийн ойг тэмдэглэхээр Сумын ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 2024 оны 07 дугаар сарын 27-нд ойн арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэж, тус арга хэмжээнд 25,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг дарга өмнө оны өр, шинээр баригдсан ЗДТГ-ын барилгын ажлын төлбөрийн өглөгийг аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 800,022.9

• 412506513

мянган төгрөг, аймгийн ОНХО-т төвлөрүүлэх 172,572.5 мянган төгрөгөөр төлж барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Дэлгэрхаан сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 335,729.5 мянган төгрөгөөр баталснаас 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 558,035.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 595,829.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэн 37,794.0 мянган төгрөгөөр буюу 6,8 %-аар биелүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг дарга болон Сумын засаг дарга нарын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ нь 2024 онд нийт 11 зорилт, 105 хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ дэвшүүлэн ажилласнаас 44 зорилтын хэрэгжилт үр дүнтэй, 12 зорилт тодорхой үр дүнд хүрсэн, 24 зорилт эрчимжүүлэх шаардлагатай, 25 зорилт хэрэгжээгүй бөгөөд гэрээний хэрэгжилт 85,9 % хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		582,997.6	735,641.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	77,488.6	232,690.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	408,930.7	400,817.6
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	96,578.4	102,133.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,250,856.5	3,215,800.7
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,250,856.5	3,215,800.7
39200	Биет хөрөнгө		3,206,976.6	3,075,033.3
39300	Биет бус хөрөнгө	13	43,879.8	140,767.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		3,833,854.1	3,951,442.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,114,372.8	71,239.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,114,372.8	71,239.3
41300	Өглөг	17а, 17б	1,114,372.8	71,239.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,719,481.3	3,880,202.9
51	Засгийн газрын хувь оролцоо		2,719,481.3	3,880,202.9
51100	Засгийн газрын оруулсан капитал		579,464.8	579,464.8
51200	Хуримтлагдсан үр дүн		1,829,001.2	2,989,722.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		311,015.4	311,015.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН		3,833,854.1	3,951,442.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруу.	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		4,134,071.7	2,871,889.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО		474,301.0	587,313.5
110	Орлогын албан татвар		164,056.7	297,575.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		171,579.6	305,098.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олгол		(7,522.9)	(7,522.9)
113	Хөрөнгийн албан татвар		24,906.1	21,618.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		285,338.2	268,119.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	776,852.8	217,649.7
120	Нийтлэг татварын бус орлого		604,951.6	217,649.7
122	Тусламжийн орлого		171,901.2	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,882,918.0	2,066,926.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,810,323.9	2,339,024.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,214,198.2	1,933,021.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,305,460.8	1,721,280.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		405,880.8	601,038.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		56,256.2	80,761.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		45,469.8	497,965.0
2104	Хангамж, бараа материалын зардал		37,026.3	45,829.9
2105	Норматив зардал		41,600.7	54,148.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		26,000.0	29,750.0
2107	Томилот, зочны зардал		4,974.0	8,718.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		20,754.0	133,604.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		667,499.0	269,465.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,908,737.4	211,740.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		596,125.7	406,003.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		323,747.8	532,864.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		323,747.8	532,864.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруул	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,768,549.6	2,733,215.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		481,823.9	587,313.5
110	Орлогын албан татвар		171,579.6	297,575.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		171,579.6	305,098.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-	(7,522.9)
113	Хөрөнгийн албан татвар		24,906.1	21,618.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж		285,338.2	268,119.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		6,906.0	9,002.6
1181	Газрын төлбөр		187.0	2,979.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		278,245.2	256,137.2
1183	Бусад татвар		-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		238,758.2	85,922.3
120	Нийтлэг татварын бус орлого		66,857.0	85,922.3
122	Тусламжийн орлого		171,901.2	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,047,967.6	2,059,979.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,074,390.7	2,119,956.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,074,390.7	2,119,956.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,165,653.3	1,908,514.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		406,192.2	596,249.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		55,944.8	84,523.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		45,469.8	497,965.0
2104	Хангамж, бараа материалын зардал		30,305.7	40,700.9
2105	Норматив зардал		41,600.7	63,795.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		26,000.0	23,920.0
2107	Томилолт, зочны зардал		4,974.0	8,718.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		14,415.9	182,708.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		540,750.1	409,934.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,908,737.4	211,441.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)		694,159.0	613,259.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		1,297,068.7	458,057.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,297,068.7	458,057.3
2200	Дотоод эх үүсвэрээр		1,297,068.7	458,057.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)		(1,297,068.7)	(458,057.3)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(V)		(602,909.7)	155,202.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3а,3б	680,398.3	77,488.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		77,488.6	232,690.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,397,182.7	-	2,397,182.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн үр дүн	(1,449.2)	-	(1,449.2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,395,733.5	-	2,395,733.5
9	Тайлант үеийн үр дүн	323,747.8	-	323,747.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,719,481.3	-	2,719,481.3
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,719,481.3	-	2,719,481.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн үр дүн	627,856.8	-	627,856.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,347,338.1	-	3,347,338.1
19	Тайлант үеийн үр дүн	532,864.8	-	532,864.8
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,880,202.9	-	3,880,202.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,193,653.3	1,886,113.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,553,733.8	1,480,110.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,532,690.5	1,459,276.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	574,716.8	537,105.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,015.9	77,015.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	533,461.0	497,965.0
2104	Хангамж, бараа материалын зардал	35,055.4	35,055.4
2105	Норматив зардал	0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,220.0	32,170.0
2107	Томилолт, зочны зардал	8,038.0	8,038.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	201,022.0	200,765.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,161.4	71,161.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,043.3	20,833.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,043.3	20,833.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	436,802.0	406,003.1
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	203,117.5	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,193,653.3	1,867,239.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	355,302.0	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,595,233.8	1,846,113.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	243,117.5	21,126.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25	25
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	T3 цэвэр дүн	T3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	122,663,926.6	450,990,102.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	122,663,926.6	450,990,102.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	112,055,878.0	435,184,980.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	21,045,966.0	59,144,278.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,313,118.0	7,507,279.0
2104	Хангамж, бараа материалын зардал	-	5,230,010.0
2107	Томилолт, зочны зардал	-	680,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураангуй	-	902,113.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,696,794.0	361,721,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,608,048.5	15,805,121.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	14,892,277.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,608,048.5	912,844.4
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	122,663,926.6	450,990,102.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	122,663,926.6	450,990,102.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 3,527,703.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 3,527,703.3 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Орон нутгийн санхүүжилтийн орлого төсвийн гүйцэтгэлийн тайланд 145,384.9 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна.
2. Аймагт төлөх өмнөх оны санхүүжилтийн өр 172,572.5 мянган төгрөгөөр төлөгдсөнийг хаалгүйгээр үлдэгдэлтэй тайлагнасан байна.
3. Үр дүнгийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайланд хоорондын тооцоо үүсгэх ЗДТГ, ИТХ, СТ, ЭМТ, ЕБС, СӨБ зэрэг байгууллагуудын санхүүжилтийн тооцоо болон бусад тооцоог үүсгээгүй, устгах бичилт 2,994,688.0 мянган төгрөг хийгдээгүй байна.
4. Нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансны үлдэгдэл 112.637.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй байна.
5. Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй орлого тодруулга тайлангаас 102,420.0 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 2,293,490.9 мянган төгрөгийн зөрчлөөс 92,729.6 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 69,300.0 мянган төгрөгөөр их тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 2,293,490.9 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 92,729.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2,193,653.3 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 7,108.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.3 Албан шаардлага

Татварын орлого нийт дүнгээрээ 37,794.0 мянган төгрөг давуулан биелүүлсэн ч нэр төрлөөрөө 4 нэр төрөлд 92,729.6 мянган төгрөгөөр тасарсан байна. Үүнийг задалбал цалингийн ашиг 6,812.9 мянган төгрөг, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар 63,088.7 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 21,911.2 мянган төгрөг, хадгаламжийн хүүгийн орлого 916.8 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 23 дугаар зүйлийн 23.1-д "Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ", 23.8-д "Сум,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага тогтоов.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд шилэн дансны цахим хуудсанд батлагдсан төсөв цэсэд ЗДТГ-ын мэдээлэл оруулсан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө байршуулаагүй, төсвийн хэмнэлтийн шалтгаан тайлбар бичигдээгүй, дараа жилийн төсвийн төсөл цэсэд ЗДТГ-ын цалингийн сангийн мэдээлэл оруулсан, Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлээгүй, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан цэсэд ЗДТГ-ын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг оруулсан, 5,0 сая төгрөгөөс дээш төгрөгийн зарлага цэсэнд мөн адил ЗДТГ-ын мэдээллийг байршуулсан, хөрөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг сүүлийн 3 сар мэдээлээгүй, Шилэн дансны цахим хуудаст байршуулбал зохих мэдээллийг ойлгомжгүй, тогтоосон хугацаанд тус тус байршуулаагүй 2,193,653.3 мянган төгрөгийн зөрчил гаргасан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.1.1-д “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.4-д “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.2.4-д “хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, төр хувийн хэвшлийн түншлэлийн жагсаалт мэдээлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага тогтоов.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт:

Татварын мэдээнээс харахад 7 нэр төрлийн орлого 93,851.0 мянган төгрөгөөр илүү, 5 нэр төрлийн орлого 86,743.0 мянган төгрөгөөр дутуу нийт дүнгээр 7,108.0 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, 24.3-д “Татварын зарлагыг нэр төрөл, салбар бүрээр нь төлөвлөж, төсвийн гүйцэтгэлд тусган дэлгэрэнгүй тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын болон татварын бус орлогын мэдээг үнэн зөв мэдээлж буй эсэхэд дотоод хяналтыг хэрэгжүүлэн гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах

2. Дотоод хяналттай холбоотой

Илрүүлэлт:

Дотоод хяналт шалгалтыг томилсон шийдвэр, ажлын төлөвлөгөөгүй дотоод хяналт хийгдээгүй байна. Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5-д "Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах шийдвэрийг гарган баталгаажуулан, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг боловсруулж, шалгалтын зорилго, хамрах хүрээ, шалгалтын аргачлал, хугацаа зэргийг тодорхойлж, хяналт шалгалтын удирдамжийг боловсруулж, шалгалт хийх багийн гишүүдэд танилцуулж, шалгалтын явцад шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, шалгалтын үр дүнг тайлагнаж, илэрсэн зөрчил, дутагдлыг засах арга хэмжээний талаар зөвлөмж өгч ажиллах

3. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Нягтгэсэн санхүүгийн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинээр гарсан заавар журамтай холбогдуулан шинэчлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, батлуулах, мөн хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулж, санхүүгийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажил зохион байгуулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	5	3,527,703.3	2	285,210.4	3	3,242,492.9	5	3,527,703.3
ЗДТГ	4	557,290.3	1	102,420.0	3	454,870.3	4	557,290.3
ОНХС	1	19,588.9	1	19,588.9			1	19,588.9
Дүн	10	4,104,582.4	4	407,219.3	6	3,697,363.1	10	4,104,582.4

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Засаг дарга	4	99,837.6			1	92,729.6	3	7,108.0		
ИТХ	1	3,000.0	1	3,000.0						
ЗДТГ	3	9,240.6	1	1,498.2			1	-	1	7,742.4
ХХС	3	405,735.1			1	258,438.9	1	85,965.6	1	61,330.6
ЭЭС	3	70,212.1	1	1,000.0	2	69,212.1				
Дүн	14	588,025.4	3	5,498.2	4	420,380.6	5	93,073.6	2	69,073.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
Тоо			Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Засаг дарга	1	2,193,653.3							1	2,193,653.3
ОНХС	1	396,802.2					1	396,802.2		
ХХС	1	356,971.9					1	356,971.9		
Дүн	3	2,947,427.4					2	753,774.1	1	2,193,653.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	3	2,947,427.40	-	-	-	-	2	753,774.1	2	4,387,307

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
	Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Өөрчлөлттэй		
		санал дүгнэлт гаргах	Түүвэрт хамрагдах	Аудит хийгээгүй		Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
1	2	3	4	5	6	7	8	9
Төсвийн шууд захирагч	2	1	1		1			
Орон нутгийн тусгай сан	4		4					
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	1				1		
Дүн	7	2	5	-	1	1	-	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn